



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 4 сарын 12 өдөр

Дугаар 546

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, түүний харьяа байгууллага болон Цагдаагийн ерөнхий газрын харьяа Дотоодын цэргийн 805 дугаар ангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 106,657,499.75 (нэг зуун зургаан сая зургаан зуун тавин долоон мянга дөрвөн зуун ерэн есөн төгрөг далан таван мөнгө) төгрөгийн балансын үнэ, 84,487,499.98 (наян дөрвөн сая дөрвөн зуун наян долоон мянга дөрвөн зуун ерэн есөн төгрөг ерэн найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 10 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал Ж.Буянбат, Цагдаагийн ерөнхий газрын дарга, хошууч генерал Ж.Болд болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;


2.4. Автомашиныг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх;

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 6 дүгээр сарын 3-ны өдрийн
576 дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН, ТҮҮНИЙ ХАРЬАА БАЙГУУЛЛАГА, ДОТООДЫН ЦЭРГИЙН
805 ДУГААР АНГИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ
АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашини нэр, марк, улсын дугаар, арал, хөдөлгүүрийн дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт (км)	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өстөг (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
Нэг. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, түүний харьяа байгууллага							
1.1 Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн							
1	Тоёота хайсе, 78-61 УНУ (арал-kdh2050039329)	2007/2018	280465	20,000,000.00	14,166,666.78	5,833,333.22	6,500,000.00
2	Тоёота региусаги, 09-64 УНУ (арал-kdh2050006188)	2004/2020	294635	5,066,666.53	3,799,999.98	1,266,666.55	1,500,000.00
3	Хьюндай соната-6, 92-03 УНУ (арал-kmhet41ар9а527365)	2008/2012	145236	21,495,833.25	21,495,833.25	-	1,500,000.00
4	Хьюндай соната-7, 02-96 УНУ (арал-kmhec41mbaa02389)	2010/2008	109492	30,000,000.00	30,000,000.00	-	5,500,000.00
	Дүн			76,562,499.78	69,462,500.01	7,099,999.77	15,000,000.00
1.2 Архангай аймгийн Шүүхийн шинжилгээний алба							
5	Хьюндай соната-5, 18-87 АРН /КМНЕМ41ВР4А948553/	2003/2017	281000	3,670,000.00	3,670,000.00	-	1,000,000.00
6	Хьюндай старекс, 18-55 АРН /КМННВР81НР1U3588/	2001/2017	310000	8,400,000.00	8,400,000.00	-	1,000,000.00
	Дүн			12,070,000.00	12,070,000.00	-	2,000,000.00

1.3 Дорноговь аймгийн Шүүхийн шинжилгээний алба							
7	Фотон, 34-70 ДГН /LVCS2NBA8DS070425/ Дүн Нийт дүн	2013/2020	189000	3,000,000.00	2,249,999.91	750,000.09	500,000.00 500,000.00 2,500,000.00
Хоёр.Цагдаагийн ерөнхий газрын харьяа Дотоодын цэргийн 805 дугаар анги							
8	Фургон УАЗ-22069, 30-17 УБП (арал-80467030)	2008/2020	238512	4,380,000.00	4,380,000.00	-	1,500,000.00
9	Паз-32053, 40-18 УБҮ (арал-х1м320530b0001286)	2011/2020	145427	6,524,999.97	6,524,999.97	-	1,500,000.00
10	УАЗ 22069, 40-13 УНҮ (арал-х1м320530b0001286)	2012/2020	121250	4,120,000.00	4,120,000.00	-	1,500,000.00
	Нийт дүн			15,024,999.97	15,024,999.97	-	4,500,000.00
	Бүгд дүн			106,657,499.75	84,487,499.98	7,099,999.77	19,500,000.00